

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН 2022 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2022.06.27

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт	Биелэлт	Үнэлгээ
Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд:				
1.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлж, урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгон, улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх.	Урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгож, улсын хэмжээнд нэгдсэн нэг бодлогоор ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр давхардалгүйгээр нэг удирдлагаар хангагдана.	Цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдийн хэмжээнд тэргүүлэх чиглэл болгон нэгдсэн бодлогоор зохион байгуулж, улсын хэмжээнд энэ оны эхний хагас жилийн байдлаар ерөнхий арга хэмжээ-11, тусгай арга хэмжээ- 445, соён гэгээрүүлэх-15, нийт 610 ажил, арга хэмжээг зохион байгууллаа.	100
2.	Байгууллагын дотоодод болон эрхлэх асуудлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, холбогдох алба хаагчдад хариуцуулан хэрэгжүүлэх. /ГХУСА33-1.1/	Төлөвлөгөөний дагуу ажил арга хэмжээ нь хариуцах эзэнтэй болсноор төлөвлөгөөний биелэлт хангагдаж үр дүн гарна.	Цагдаагийн байгууллагаас 2022 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 60 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний энэ оны эхний хагас жилийн биелэлтийг харьяа алба, нэгжүүдээс авч нэгтгэн, үр дүнг тооцсон.	100
3.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх инфографик, шторк, контент болон сэрэмжлүүлгийг салбар, байгууллагын цахим хуудас, сайт, мэдээллийн самбарт тогтмол байрлуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх. /ГХУСА33-1.2/	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бүтээсэн контентийг цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт тогтмол байршуулснаар иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилнэ.	Энэ оны эхний 06 сарын байдлаар хэвлэл, мэдээллийн байгууллагад 650 удаагийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон цаг үеийн мэдээллийг өгсөн байна. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага 35 цахим сайт, 57 нүүр хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ, мэдээллийг нэг цонхоор дамжуулж байгаагаас гэмт хэрэг, зөрчлийн талаар 534, урьдчилан сэргийлэх чиглэлээр 3384, алба хаагчийн үйл ажиллагаа, алдар гавьяаг алдаршуулах чиглэлээр 1348, бусад 653 мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд түгээсэн. “Монгол төрийн цагдаа” эмхэтгэлийн 2021 оны IV дугаар улирлын болон 2022 оны I улирлын дугаарыг “Адмон” ХХК-ны хэвлэлтээс тус бүр 2000, нийт 4000 ширхгийг хүлээн авч Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, цагдаа, дотоодын	100

			<p>цэргийн анги, байгууллагад хуваарийн дагуу тараан олгож, 2022 оны II улирлын сэтгүүлийг бэлтгэж байна.</p> <p>Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээллийг түгээх ажлын хүрээнд “Амрыг эрье” 15, 20, минутын нэвтрүүлгийн нийт 48 удаагийн дугаар бэлтгэж МҮОНТ-ийн 1, 2 дугаар сувгаар, Эх орон, Боловсрол, Etv, Tv-5, Tv-4, Tv-9, Otv, News Chanel, Сүлд зэрэг нийт 12 телевизээр 96 удаагийн давталттайгаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажилласан.</p> <p>“Police podcast” хөтөлбөрийн хүрээнд төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтэстэй хамтран 19 удаагийн ярилцлага бэлтгэн түгээсэн.</p>	
4.	<p>Төрийн алба хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх ажлыг сайжруулах. /ГХУСА33-1.3/</p>	<p>Алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлага дээшилж, авлига, албан тушаалын гэмт хэрэгт өртөхгүй байх, төрийн үйлчилгээ иргэдэд шуурхай хүрнэ.</p>	<p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг энэ оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор сахилгын зөрчлийн бодит жишээн дээр тулгуурласан богино хэмжээний 42 киног анги, байгууллагуудад хуваарилан бэлтгүүлж, 9 төрлийн 17 видео шторкыг “Алба хаагчдын чөлөөт индэр” хаалттай фэйсбүүк группт байршуулж, алба хаагчдад мэдээлэл хүргэн, давхардсан тоогоор 58800 алба хаагч үзэж, 1300 алба хаагч санал, сэтгэгдлээ ирүүлсэн нь үйлдэгдэж буй зөрчлийг таслан зогсоох урьдчилан сэргийлэх, зөрчиж буй хууль, журмын ойлголтыг тайлбарлан хүргэсэн ажил, арга хэмжээ болсон.</p> <p>Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн алба хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх, ёс зүйг дээшлүүлэх, байгууллагын соёлыг тогтоох зорилгоор Авлигатай тэмцэх газраас улсын хэмжээнд зохион байгуулж буй “Зөв зөвд, шударга зөв” аяныг байгууллагын алба хаагчдад сурталчилж, “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” пейж фэйсбүүк хуудаст QR кодыг уншуулан нэгдэх, дагах ажлыг зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй “Зөв зөвд, шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Өнөөдрийг маргаашийн</p>	100

			<p>бахархал болгоё” өдөрлөгийг энэ оны 5 дугаар сарын 20-ны өдөр Дотоод хэргийн их сургуультай хамтран төгсөх дамжааны 500 гаруй оюутныг хамруулж, авлигатай тэмцэхэд “ТАНЫ ХЭЛЭХ УРИА” үг зохиох уралдаан, “Чөлөөт индэр мэтгэлцээн”-ий тэмцээнийг зохион явууллаа.</p> <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, мөн хуулийн 23.8-д заасан хяналт шалгалтаар томилогдон ажиллахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлж мэдэгдэл, тайлбар гаргасан 150 алба хаагч, 23 дугаар зүйлийн 23.5-д заасны дагуу анги, байгууллагад дэвшин, шилжин, шинээр томилогдсон 1405 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг бүрдүүлэлтийн https://meduuleg.iaac.mn цахим санд бүртгэсэн.</p>	
5.	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх агуулга бүхий нийтлэл, мэдээлэл бэлтгэн нэвтрүүлэх, түүний нийт мэдээлэлд эзлэх хувь хэмжээг тогтоох тухай журмын төслийг боловсруулж, батлуулах. /ГХУСА33-1.4/	Журмын төсөлд тусгуулах санал боловсруулж, хүргүүлсэн байна.	Одоогийн байдлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тухайн журмын төсөлд санал авахаар ирүүлээгүй байна.	-
6.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллага үнэ төлбөргүй нийтэлж, нэвтрүүлэх журмын төслийг боловсруулж, батлуулах. /ГХУСА33-1.5/	Журмын төсөлд тусгуулах санал боловсруулж, хүргүүлсэн байна.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйл /Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг/-ийн 32.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 32.2-т заасан хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасан. Одоогийн байдлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тухайн журмын төсөлд санал авахаар ирүүлээгүй байна.	-
7.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах	Журмын төсөлд тусгуулах санал боловсруулж, хүргүүлсэн байна.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.3-т заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтран батлах “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам”-ын төсөлд тусгуулах саналыг 2022 оны 2/49 дугаартай албан бичгээр Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн.	100

	<p>журмыг боловсруулж, батлуулах. /ГХУСА33-1.6/</p>		<p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.4-т заасан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журамд санал авахаар эрх бүхий албан тушаалтан, байгууллагаас одоогоор төсөл ирүүлээгүй байна.</p>	
<p>8.</p>	<p>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулах, эрх бүхий байгууллагад хүргүүлэх. /ГХУСА33-1.7/</p>	<p>Хуулийн төсөлд тусгуулах санал боловсруулж, хүргүүлсэн байна.</p>	<p>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Засгийн газраас 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль нь 7 бүлэг 45 зүйлтэй.</p> <p>Одоо хуулийн төсөл Улсын Их Хуралд анхны хэлэлцүүлгийн шатанд байгаа бөгөөд цагдаагийн байгууллагыг төлөөлөн Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Нийтийн хэв журам хамгаалах хэлтсийн дарга ажиллаж байгаа болно.</p> <p>Төсөлд согтууруулах ундааны хэрэглээ, түүний худалдаатай холбоотой үйл ажиллагааны талаарх дараах шинэлэг зохицуулалтыг хуулийн төслийн энэхүү бүлэгт тусгасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл эзэмшигч нь үйлчлүүлэгчид зориулсан худалдан авсан согтууруулах ундааг хэрэглэх танхимтай байх; -Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс худалдан авсан согтууруулах ундааг зөвхөн дээр дурдсан танхимд хэрэглэх; -Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 35 хувиас дээш хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундааг үйлдвэрийн лонх, савлагаатай нь худалдаж үйлчлэхийг хориглох; -Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний танхимдаа халуун, хүйтэн зуушаар үйлчлэх болон ундны усаар үнэ төлбөргүй үйлчлэх; -Согтууруулах ундаагаар үйлчлэх танхимд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох болон хэтрүүлэн хэрэглэсний улмаас үүсэх хор уршгийн талаар санамж, такси, нийтийн тээврийн үйлчилгээний талаарх мэдээллийг байршуулах; -Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь 	<p>100</p>

		<p>согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамрагдсан байх;</p> <p>-Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан нь үйлчлүүлэгч хуульд заасан насанд хүрээгүй гэх үндэслэл байгаа тохиолдолд үйлчлэхийн өмнө хуулиар зөвшөөрөгдсөн насанд хүрсэн эсэхийг шалгах зорилгоор үйлчлүүлэгчийн бичиг баримтыг заавал шалгах;</p> <p>-Хорин нэгэн насанд хүрээгүй, эсхүл согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсний улмаас бусдад учруулсан гэм хорыг согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцах.</p> <p>Мөн архидан согтуурах, согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэх зорилго бүхий аливаа үйл ажиллагааг хориглох зохицуулалтуудыг тусгасан. Тухайлбал:</p> <p>-Зар сурталчилгааны тухай хуулийн 141.4-т зааснаас бусад тохиолдолд спортын, соёл, урлагийн болон нийтийг хамарсан арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах, байршуулах;</p> <p>-Төрийн бэлгэ тэмдэг, түүхэн хүний нэр, зургийг, согтууруулах ундааны нэр, лого, барааны тэмдэг, зураг, сурталчилгаанд ашиглах;</p> <p>-Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хямдрал, урамшуулал зарлах, хөнгөлөлттэй үнэ, нөхцөлөөр худалдах, үйлчлэх болон урамшуулал, хөнгөлөлтийг илэрхийлсэн утгатай зар сурталчилгаа ашиглах;</p> <p>-Согтууруулах ундаагаар дээж, загвар хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчлэх, бусдыг дайлах, амтлагаа зохион байгуулах;</p> <p>-Нэг тогтоосон үнээр хязгааргүй хэмжээгээр согтууруулах ундаагаар үйлчлэх;</p> <p>-Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч согтууруулах ундааг зээлээр худалдах, түүгээр зээлээр үйлчлэх;</p> <p>-Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээний талаар төрөл бүрийн сугалаа, хонжвор, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа явуулах;</p> <p>-Согтууруулах ундааны нэрээр хуулийн этгээдийг нэрлэх, эсхүл хуулийн этгээдийн нэрээр согтууруулах ундааг нэрлэх;</p> <p>-Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэйгөөс бусад газарт эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах</p>
--	--	--

			ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэх зэргийг хориглохоор гэж тус тус тусгасан.	
9.	Олон Улсын төсөл болон Үндэсний хөтөлбөр /Коломбо, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр гэх мэт/-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх. /ГХУСА33-1.8/	Хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн байна.	“Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, чиг үүргийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, сургаж мэргэшүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, донтогчдод үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг шинэ шатанд гаргах талаар хэлэлцэж ГХУСА33-өөс “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Хар тамхитай тэмцэх газраас дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлэх 4 бүлэг, 18 заалт бүхий салбар төлөвлөгөө, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 06/05 дугаартай “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” зөвлөмжийг хэрэгжүүлэх 11 заалт бүхий 2022 оны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
10.	Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах. /ГХУСА33-1.9/	Төлөвлөгөөнд заагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангасан байна.	Цагдаагийн байгууллагаас “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”, “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”, “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх”, Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийн хуралдаанд тус тус оролцож, 2021 онд хийсэн ажлаа тайлагнаж, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. “Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийг татан буулгаж, Зам тээврийн хөгжлийн яамны дэргэдэх “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл”-тэй нэгтгэх шийдвэр гарсан.	100
11.	“Гэмт хэргийн цагаан ном-2021” эмхтгэлийг бэлтгэн гаргах. /ГХУСА33-1.13/	“Гэмт хэргийн цагаан ном-2021” эмхтгэл хэвлэгдсэн байна.	Монгол Улсад 2021 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал товхимол номыг бэлтгэн 250 ширхэгийг энэ оны 01 дүгээр сарын 31-ны өдөр хэвлүүлж, Хууль зүй дотоод хэргийн яам, цагдаагийн байгууллагын харьяа холбогдох нэгж, эрдэм шинжилгээний байгууллагуудад хүргүүлсэн. Дээрх товхимол номны 2021 оны цувралын зохиогчийн эрхийг Цагдаагийн Ерөнхий газрын нэр дээр бүртгүүлж, Оюуны өмчийн газрын 13763 дугаар бүхий гэрчилгээг авсан.	100

12.	Гадаадад гэмт хэргийн хохирогч болсон иргэдэд үзүүлж буй эрх зүйн болон санхүүгийн дэмжлэг туслалцааг нэмэгдүүлэх. /ГХУСА33-1.16/	Эрх зүйн болон санхүүгийн дэмжлэг нэмэгдсэн байна.	<p>Монгол Улсад Гэмт хэргээс Урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг хүлээсэн цагдаа, тагнуул, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяат, мэргэжлийн хяналт, эрүүл мэндийн байцаагч, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын мэргэжилтэн, гадаад хэргийн яамны консулын газар зэрэг төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн “Дэд зөвлөл”-ийн хурал улирал тутамд хуралдаж ажилласнаар төрийн бодлого, үйл ажиллагаа тодорхойлогдож, салбар байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, үүрэг хариуцлагаа ухамсарладаг эерэг байдал бий болсон.</p> <p>Сүүлийн 5 жилийн байдлаар Гадаад улсад хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч болсон, виз, оршин суух баримт бичгийн хугацаа хэтрүүлсэн, торгууль, төлбөрт орсон Монгол Улсын 46 иргэнийг 6 улсаас эх оронд нь аюулгүй буцаан авчрах ажлыг Гадаад харилцааны яамны Консулын газар, Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллага, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран зохион байгуулсан. Үүнд:</p> <p>Гадаад улсад хохирсон иргэдийг 2017 онд БНХАУ-аас 7, 2018 онд Камбож 4, Мьянмар 3, Малайз 2, Хятад 14, 2019 онд БНТУ-аас 1, 2020 онд Малайз Улсаас 15 хохирогчийг аюулгүй буцааж ирүүлсэн. Энэ онд гадаад улсад хохирогчоор тогтоогдсон иргэн байхгүй.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт 105 хүүхдэд зөвшөөрөл өгч Excel программ дээр бүртгэж хяналт тавьж ажилласан.</p>	100
13.	Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлэх боломжийн чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулах./ГХУСА33-1.18/	Хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн байна.	<p>“Clubhouse” апп ашиглан “Согтууруулах ундаа ба тээврийн хэрэгсэл”, “Мотоциклийн стандарт хэрэглээ ба бодит байдал” сэдвүүдийн хүрээнд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Замын цагдаагийн нэгжийн 123 дарга нарыг хамруулан цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж, цахим хуудсаар түгээсэн нь нийт 9510 хүнд хүрсэн байна.</p> <p>Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил, түүний хор уршгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсад ямар бодлого чиглэл баримталж, хууль дүрмээрээ хэрхэн</p>	70

			<p>шийдвэрлэсэн талаар 18 улсын замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль журамтай харьцуулсан судалгааг хийж танилцуулгаар Хууль зүй яаманд хүргүүлсэн.</p> <p>Зам тээврийн осол, хэрэг ихээр гардаг Хан-Уул дүүргийн 12, 13, 14, Архивын зам /Өлзийт хороолол/, Био комбинат, Шувуун fabriкийн зам, 11-р хороо Дүнжингаравын гудамж буюу уулын замуудад болзошгүй зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, эзэн холбогдогч нь тодорхойгүй хэргийг түргэн шуурхай илрүүлэх зорилгоор дугаар илрүүлэгчтэй камер байршуулах шаардлагатай байршлуудын судалгааг Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт албан бичгээр хүргүүлж, дүүргийн худалдан авах ажиллагааны газраас 2022 оны 02 дүгээр сарын 08-ны өдөр тендэр зарлан Сонголт нар ХХК шалгарсан. Дээрх байршилд 282 сая 910 мянган төгрөгийн төсөвтэй хяналтын камеруудыг байршуулан энэ оны 8 дугаар сард хүлээлгэн өгөх зураг төсөв батлагдсан. Одоогоор ажлын гүйцэтгэл 25%-тай явагдаж байна.</p>	
14.	<p>Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам зэрэг холбогдох эрх зүйн зохицуулалтуудыг батлах, боловсронгуй болгох. /ГХУСА33-1.19/</p>	<p>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан заалт хэрэгжиж, эрх зүйн орчин сайжирна.</p>	<p>Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төв, Эрүүл мэндийн яам хамтарсан ажлыг хэсгийг байгуулан ажиллаж ажлын хэсгээс Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/305 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн хуудсыг цахим хэлбэрт оруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	90
15.	<p>Гудамж, зам талбайд ашиглагдаж байгаа камерын ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулах, шинээр суурилуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.</p>	<p>Тодорхой төрлийн гэмт хэргийн гаралт буурч, илрүүлэлтийн хувь нэмэгдсэн байна.</p>	<p>Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд автобусны буудлуудыг камержуулах чиглэлээр 6,4 тэрбум төгрөгний санхүүжилтийн тооцоог гаргаж саналыг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 26/2150 дугаартай албан бичгээр Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд хүргүүлж, энэ онд гэмт хэрэг зөрчил ихээр үйлдэгддэг нийтийн тээврийн автобусны буудлуудыг камержуулахад 799 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар телехяналтын камерын хяналтаар 21 гэмт хэрэг, 57 зөрчлийг илрүүлэн, хуулийн дагуу</p>	90

			шалгаж, шийдвэрлэсэн.	
16.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг олон талт хэлбэрээр идэвхжүүлэх.		Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зорилт, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад “Оюутан цагдаа” арга хэмжээнд шаардагдах төсвийг шийдвэрлүүлэхээр албан бичиг хүргүүлснээр 157,176,000 төгрөгийг шийдвэрлүүлж, Монголын Оюутны Холбоотой хамтран ажиллаж 240 иргэнийг бүртгэж, судалгааг гарган, Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран сонгон шалгаруулалтыг явуулж, 168 оюутан тус хөтөлбөрт хамрууллаа. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчны яам, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Аялал жуулчлалын яам, Монголын оюутны холбооноос хамтран зохион байгуулж буй Оюутан цагдаагийн ажиллах эргүүлийн чиглэл, нэгдсэн байршлын судалгааг нэгтгэж, оюутан цагдаа нарын өмсөх гэрэл ойлгогчтой хантааз, саравчтай малгайны тооцооллыг хийж, “Цагаан шонхор” оёдлын үйлдвэрт захиалга өгч, энэ оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрийн хооронд ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж, “Оюутан цагдаа-2022” хөтөлбөрийн нээлтийг 2022 оны 06 дугаар сарын 16-нд хийсэн.	90
17.	Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гудамж, талбайд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах.		Хууль зүй, дотоод хэргийн сайдын өгсөн үүрэг, санаачлагаар Нийслэлд морьт эргүүлийн үйл ажиллагааг өргөтгөх төслийг шинээр боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарт танилцуулж төсөв хөрөнгийг шийдвэрлүүлснээр энэ оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс Нийслэлийн Туул голын эрэг дагуу морьт, мото, ATV эргүүлийг 10 чиглэлд 25 алба хаагчтай ажиллуулж эхлээд байна.	100
18.	Залилах гэмт хэргийн гаралтыг бууруулах, бүртгэгдсэн хэргүүдийн шийдвэрлэлтийг ахиулах, иргэдэд учирсан хохирлыг барагдуулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажлын хэсэг байгуулж ажиллах.	Залилах гэмт хэргийн гаралт буурсан байна	Цагдаагийн байгууллагаас “Залилах” гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хэргийн шийдвэрлэлтийг ахиулах үүрэг бүхий ажлын хэсгийг ЦЕГ-ын Тэргүүн дэд даргын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар байгуулж, ажлын хэсгээс хийж гүйцэтгэх ажил төлөвлөгөөг боловсруулан 03 дугаар сарын 15-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргаар батлуулсан. Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан “Залилах” гэмт хэрэг жил дарааллан өссөн үзүүлэлттэй байгаа ба 2011 онд 688 бүртгэгдэн, шалгагдаж байсан бол 2021 онд 6679 болж 10 дахин өсч, нийт гэмт хэргийн дотор эзлэх хувь 24.5 хувь болж өссөн.	100

			<p>Дээрх гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор мэдээлэл, сурталчилгаа, ухуулга нөлөөллийн ажлыг энэ оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд зохион байгуулж иргэн, хуулийн этгээдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, санхүүгийн болон хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 71 телевизээр мэдээлэл өгч, хэлэлцүүлэг явуулж, 25 сайтад зорилтот нийтлэл хэвлүүлж, нийт 21 постер, 19 видео шторк, 13 подкаст, лайв бэлтгэн цахим орчинд түгээлт хийсэн нь нийт 10,024,438 хүнд хүрсэн байна.</p>	
Хоёр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд:				
2.1. Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр				
19.	<p>Замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, дүрэм журмын хэрэгжилтийг хангах зорилгоор -40 градуст ажиллах боломж бүхий дүрс бичлэгийн техник, тоног төхөөрөмжийг засварлах, сэлбэх, шинэчлэн суурилуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх. /ГХУСАЗЗ-2.1.1/</p>	<p>Зам тээврийн осол, гэмт хэрэг буурах ба хэрэг, зөрчил гарсан тохиолдолд нотлох баримтын шаардлага хангагдана.</p>	<p>Албан журмын даатгагчдын холбооны 1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Багахангай, Багануур, Архангай аймгийн Тариат, Ихтамир, Хашаат, Дундговь аймгийн Мандалговь, Төв аймгийн Лүн, Сэргэлэн, Сэлэнгэ аймгийн Баруун хараа, Хэнтий аймгийн Цэнхэр мандал сумын 10 постыг камержуулах чиглэлээр Тээврийн цагдаагийн албаны ЦЕГЗЦА/202105010 дугаартай “Олон улсын болон улсын чанартай автозам дагуу байрлах байнгын хяналтын цэг /пост/-ийг улсын дугаар таних, зөрчил илрүүлэх, бусад хяналтын камер, тоног төхөөрөмжөөр тоноглох”, тендэрийн хороонд алба хаагч томилон худалдан авах ажиллагааг зохион байгуулж нээлттэй тендерт оролцох санал ирүүлсэн компаниудын тендерийн баримт бичгийн техник, тоног төхөөрөмжийн харьцуулалт, үнэлгээг хийж, ТЦА-нд байгуулагдсан ажлын хэсэгт цахимаар хүргүүлж хамтран ажилласан.</p> <p>Нийслэлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс Нийслэлийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд телехяналтын чиглэлээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, төслийн санал боловсруулах ажлын хүрээнд “Улаанбаатар хотоос гарах, орох пост, шалган нэвтрүүлэх товчоо, “Их бага тойруу”, алсын чиглэлийн хөдөлгөөний хяналт”, “Улаанбаатар хотын гудамж зам, талбайг камержуулах төсөл”-ийн танилцуулгыг Нийслэлийн Цагаагийн удирдах газар, Тээврийн цагдаагийн албатай хамтран боловсруулсан.</p> <p>Энэ оны эхний хагас жилийн байдлаар замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдлын чиглэлээр суурилуулсан дүрс бичлэгийн төхөөрөмжийг засварлах, сэлбэх, шинэчлэн суурилуулах ажил, арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно.</p>	90

20.	<p>Хот, суурин газрын зам дагуу болон төлөвлөгдсөн замын байгууламжийн талбайд олгосон хууль бус газар олголтод хяналт шинжилгээ үнэлгээ хийх, авто зам дагуу аюултай нөхцөлд байрлах айл, өрхийг аюулгүй байршилд нүүлгэн шилжүүлэх, тэднийг аюул, ослоос урьдчилан сэргийлж аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд замын дэглэм зөрчсөн байдалд нэг бүрчилсэн ажил арга хэмжээг Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу нэг бүрчилсэн арга хэмжээ авах асуудлыг шийдвэрлүүлэх. /ГХУСА33-2.1.2/</p>	<p>Иргэд, олон нийтийг учирч болох ослын аюулаас урьдчилан сэргийлнэ.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/388 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас нийтийн эдэлбэр газарт зөвшөөрөлгүй барьсан гараашуудыг буулгах ажилд 4 дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эдэлбэр газарт зөвшөөрөлгүй газар эзэмшиж байсан нийт 221 тоосгон гараашийг буулгах ажлыг Нийслэлийн газар зохион байгуулалтын албатай хамтран Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.</p>	90
21.	<p>“Зөвийг хэвшүүлье” аяныг хамгаалалтын бүс, мотоциклын малгай, хүүхдийн хамгаалах суудал, явган хүний гарцаар нэвтрэх соёлыг хэвшүүлэх олон нийтэд ухуулан таниулах, сургалт, нэвтрүүлэг олон нийтийн хэрэгслээр явуулах, хяналт шалгалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. /ГХУСА33-2.1.3/</p>	<p>Орон нутгийн зам дахь осол, хэргийн тоо буурч, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг сайжирна.</p>	<p>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх чиглэлээр “Олон Улсын Автомашины Холбоо” /Fédération Internationale de l'Automobile “FIA”/ холбооноос гаргасан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын алтан дүрэм”-ийн ололтой талыг Монгол улсын Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтуудтай уялдуулж энэ онд 10 төрлийн нөлөөллийн ажил арга хэмжээг “Зөвийг хэвшүүлье” уриатайгаар зохион байгуулахаар календарчилсан төлөвлөгөөний хүрээнд эхний хагас жилд “Зөвийг хэвшүүлье” уриатай “Уусан бол бүү жолоод”, “Гар утас”, “Гэрлээр анхааруулъя”, “Хамгаалах малгай”, “Явган зорчигч”, “Сургууль орчмын бүс-Хүүхэд” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, үр дүнг тооцсон. Тухайлбал:</p> <p>“Сурагчийн аюулгүй байдал эцэг эх асран хамгаалагчийн үүрэг” арга хэмжээний хүрээнд хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн “Хүүхдийн төлөө бидний оролцоо” зөвлөгөөнд 1000 эцэг эх оролцсон модуль сургалт зохион байгуулж, мөн 232 байгууллагын 27824 иргэнд Хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулж,</p>	100

			зөрчлийн тухай хуулийн 14.7.45 дахь хэсэгт заасан заалтыг зөрчсөн 1439 жолооч эцэг эх асран хамгаалагчдыг 86.950.000 төгрөгөөр, мөн хуулийн 14.7.54 дахь заалтаар 20 эцэг эх асран хамгаалагчийг 1.000.000 тус тус торгож арга хэмжээ авсан.	
22.	Жолооч бэлтгэх сургалтыг чанаржуулах, эрх зүйн орчны судалгаа хийж төсөл бэлтгэж батлуулах. /ГХУСА33-2.1.4/	Жолоочийн мэдлэг, ур чадварт тавигдах шаардлага нэмэгдэнэ.	Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн яамны Ажлын хэсгийн хуралдаанд цагдаагийн байгууллагыг төлөөлөн Хуулийн хэлтсийн дарга санал, дүгнэлт боловсруулж ажилласан бөгөөд Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Арван дөрөвдүгээр бүлэгт тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчлийг тусгасан. Одоогийн байдлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын төсөлд санал авахаар ирүүлээгүй байна.	90
2.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр				
23.	Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрыг шинээр болон бүсчлэн байгуулах талаар холбогдох судалгаа хийж, шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад хүргүүлэх./ГХУСА33-2.2.1/	Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар шинээр болон бүсчлэн байгуулах талаар холбогдох судалгааг хийж, санал хүргүүлсэн байна.	Хөвсгөл, Дорнод, Хэнтий, Баянхонгор, Баян-Өлгий, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар, хэлтсүүд аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, төрийн болон төрийн бус байгууллагатайгаа хамтран Архидан согтуурахтай тэмцэх дэд хөтөлбөр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газар төрийн 14 байгууллагын 310 алба хаагч, ерөнхий боловсролын 1305 сурагч, 9 аж ахуй нэгжийн 830 ажилчдыг арга хэмжээнд нэгдүүлж, “Архигүй Хөвсгөл” хөтөлбөрийг санаачлан аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч нарын хуралдаанаар хэлэлцүүлэн 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр батлуулсан. Баянхонгор аймаг дахь цагдаагийн газраас согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архины хор хөнөөлийг иргэдэд сурталчлах, архины хамаарал бүхий /донтогч/ иргэдэд эмнэлгийн болон нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Жаргалтай амьдрал” төвийг байгуулсан.	90

			Баянхонгор аймагт архи, согтууруулах ундаанд донтох эмгэгтэй иргэдийг эмчлэх “Жаргалтай амьдрал” сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийг үүсгэн байгуулсан тухай төсөл, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад энэ оны 13-2/819 дугаар албан бичиг, улсын хэмжээнд хэрхэн зохион байгуулах, шинэ санал, санаачлага гарган ажиллах чиглэлээр 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр 13/768 дугаартай албан бичгээр үүрэг, ажлын чиглэл тус тус хүргүүлээд байна.	
24.	Дэмжих бүлгийн гарын авлага боловсруулж, хэвлүүлэх, зорилтот бүлэгт хүртээл болгох. /ГХУСА33-2.2.3/	Гарын авлага хэвлэгдэж, зорилтот бүлэгт хүрсэн байна.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эцэг эх, багш нийгмийн ажилтан нарт мэдээлэл өгөх чиглэлээр 16 их дээд сургуулийн 317 багш, ерөнхий боловсролын 57 сургуулийн 1250 багш, нийгмийн ажилтан нийт 1567 хүнд сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж, хор уршиг, үр дагавар, хууль эрх зүйн мэдээлэл өгөх агуулга бүхий 4 төрлийн 21300 ширхэг гарын авлагыг тараасан.	100
25.	Зэрлэг байдлаар ургаж буй мансууруулах үйлчилгээтэй ургамлыг устгах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тархац тогтоогдсон аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулах. /ГХУСА33-2.2.4/	Устгалын ажлыг зохион байгуулсан байна.	“Монгол Улсын зарим нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах болон донтуулах үйлчилгээ бүхий ургамлын тархалтыг зогсоох, устгах чиглэлээр цаашид хийж хэрэгжүүлэх шаардлагатай ажлын санал, мансууруулах болон донтуулах үйлчилгээ бүхий ургамлыг устгах нийт талбайн хэмжээ, зардлын тооцоог Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга Л.Нямгэрэлд 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 16/618 дугаартай албан бичгээр танилцуулсаны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдаас устгалын бэлтгэл ажлыг хангах, үр дүнтэй зохион явуулах тухай хугацаатай үүргийг тархац тогтоогдсон 11 аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга буюу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбарын дарга нарт хүргүүлсэн. “Устгал” нэгдсэн арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албатай хамтран Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчны сайдын хамтран батлах “Устгал-2022” арга хэмжээний удирдамж, төлөвлөгөө, хавсралтын төслийг боловсруулаад байна. Мөн арга хэмжээний удирдамжийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар хамтран батлуулахаар хэлэлцэж, тус яам болон орон нутаг дахь Хүнс, хөдөө аж ахуйн газруудад	90

			хариуцуулан хэрэгжүүлэх ажлын саналыг энэ оны 05 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанд цахимаар хүргүүлсэн. Дээрх удирдамж төлөвлөгөөний дагуу цагдаагийн байгууллагаас “Устгал-2022” нэгдсэн арга хэмжээг зохион явуулах ажлын төлөвлөгөө, үүрэг ажлын чиглэлийг Цагдаагийн ерөнхий газрын даргаар, ажиллах маршрутыг тэргүүн дэд даргаар батлуулахаар төслийг боловсруулж энэ оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	
26.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагад шаардлагатай програм хангамж, техник хэрэгсэл, багаж нийлүүлэх. /ГХУСА33-2.2.5/	Шаардлагатай программ хангамж, техник хэрэгсэл, хөрөнгө оруулалт хийгдсэн байна.	Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын мэдээллийн санг бүрдүүлж, тандалт судалгаа, дүн шинжилгээний ажил гүйцэтгэх, шинжээч, мөрдөгч нарт шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах ажлын хүрээнд Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн 23 дугаар захирамжаар 20.000.000 / хорин сая/ төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж иж бүрэн суурин компьютер 3 ширхэг, дэлгэц 7 ширхэг, принтер 1 ширхэгийг тус газарт хүлээлгэн өгснийг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100
2.3. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр				
27.	Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх. /ГХУСА33-2.3.1/	Үнэлгээ хийж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Хүн худалдаадахтай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдахаас өмнө 2016 оныг хүртэлх хугацаанд (хүн худалдаалах) зүйл ангиар жилдээ 1-2 хэрэг шүүхээр шийдвэрлэгддэг байсан бол хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд жилд дунджаар 3 хэрэг буюу нийт 14 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн эерэг үзүүлэлт гарсан нь урьдчилан сэргийлэх ажлыг амжилттай зохион байгуулсны үр дүн гарсан.	90
28.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлэх. /ГХУСА33-2.3.2/	Энэ төрлийн хэрэгт өртөж хохирсон иргэдийн зөрчигдсөн эрх ашиг хангагдана.	Цагдаагийн байгууллагаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нийт 223 хүнийг тогтоосон бөгөөд үүнээс 158 хохирогчийг ГБХЗХГ-т хүлээлгэн өгч, хүний эрх, гэр бүлийн болон нийгмийн ажилтан, багш нар, хүүхэд хамгаалал, хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын ажилтнуудтай мэдээ, мэдээлэл солилцож хамтран ажилласан.	100

			Ихэнх тохиолдолд өмгөөллийн болон хууль эрхзүйн туслалцаа, хамгаалах байр, ар гэрийн эдийн засгийг дэмжих, цогц үйлчилгээнд хамруулсан байна.	
29.	Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах. /ГХУСА33-2.3.3/	Сургалт зохион байгуулагдаж, үр дүнг тооцсон байна.	Нийслэл, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүд тус бүрээс 1 алба хаагчийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн сургалтад хамруулж, ЭЦА-ны чиглэл хариуцсан хэлтэст сарын хугацаагаар ажиллуулан туршлага, судлуулж мэргэшүүлсэн. Түүнчлэн “Хууль зүй, дотоод хэргийн яам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газар, “Азийн сан”, “Хүйсийн тэгш эрх төв” зэрэг төрийн болон төрийн бус олон улсын байгууллагуудаас зохион явуулсан 27 удаагийн 235 цагийн сургалтад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэл хариуцсан болон дүүрэг, орон нутгийн цагдаагийн газар хэлтсийн алба хаагчид хамрагдсан.	100
30.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч иргэдийг зохих сургалтад хамруулж, ажлын байраар хангах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах. /ГХУСА33-2.3.4/	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулж, ажлын байраар хангах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нарыг төрийн бус байгууллагатай хамтран хохирогчийн эрхийг хангах цогц үйлчилгээ үзүүлж тэднийг 11 хохирогчийг өөрсдийн хүсэл, сонирхлын дагуу үсчин, гоо сайханы дамжаанд суралцуулсан.	90
2.4. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх				
31.	“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт Үндэсний чуулган зохион байгуулах. /ГХУСА33-2.4.1/	Үндэсний чуулган зохион байгуулагдаж, зөвлөмж гарсан байна.	“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” үндэсний чуулганд оролцох 800 хүний албан тушаал, зам, хоолны зардлын тооцоог боловсруулж, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах ажлын албанд хүргүүлсэн. Чуулганыг энэ оны III улиралд зохион байгуулахаар төлөвлөж байна.	-
32.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийлгэх. /ГХУСА33-2.4.2/	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар дээшилнэ.	Олон Улсын эрх зүйн байгууллага “IDLO”-ийн дэмжлэгтэйгээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийлгэх байгууллагын сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх иргэн, байгууллага сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зарласан боловч шаардлага хангасан байгууллага материалаа ирүүлээгүй байгаа тул дахин тендерийг зарлахаар ажиллаж байна.	70

33.	Хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн жишиг хуваарийн төсөл боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлж, батлуулах. /ГХУСА33-2.4.3/	Хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн жишиг хуваарийн төсөлд санал боловсруулан хүргүүлсэн байна.	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолтод хийсэн дүн шинжилгээний тайлангийн хэлэлцүүлэг зохион байгуулах үед цагдаагийн байгууллагаас 7 алба хаагч оролцсон. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн жишиг хуваарийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулаагүй байна.	70
-----	--	---	--	----

2.5. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх

34.	Хилийн зурвас, бүсэд үйлдэгдэх гэмт хэрэг, хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль сахиулах байгууллагууд болон орон нутгийн засаг захиргаатай хамтран Увс, Сэлэнгэ, Хэнтий аймгийн хилийн хэсэгт хилийн хамтарсан ажиллагаа явуулж, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах. /ГХУСА33-2.5.1/	Хилийн тухай шинэчилсэн найруулгын хуулийн 35 дугаар зүйлийн хэрэгжилт хангагдана.	Увс аймаг дахь Цагдаагийн газрын санаачилгаар ОХУ-ын Тува Улсын Засгийн газар болон Тува Улс дахь холбооны хууль хяналтын байгууллагуудын хил орчмын хамтын ажиллагааны асуудлаарх цахим хурлыг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Уг хуралд Тува улсын Засгийн газрын тэргүүний хууль эрх зүй, аюулгүй байдлын асуудал хариуцсан орлогч дарга Тимур Борисович Куулар, Кызыл хотноо суугаа Ерөнхий консул Ч.Ганболд, аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Болор-Эрдэнэ, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа Т.Сүхболд нар оролцсон. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2000 оны хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газраас Хилийн цэргийн 0285 дугаар ангитай хамтран хилийн бүсийн сумуудын “Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх комисс”-ын хамтарсан сургалтыг Цагааннуур сум, Улаанбайшинтын боомт, хилийн бүс газарт 2022 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Улаанхус, Цагааннуур тосгон, Ногооннуур сумын засаг дарга, Тамгын газрын дарга, багийн Засаг дарга, малын эмч нарыг оролцуулан онолын мэдлэг олгох, бүлгээрээ ажиллах, практик дадлага сургуулилт гэсэн 3 үе шатаар зохион байгуулсан. Оросын Холбооны Улсын Дотоод Хэргийн яамны харъяа Өвөрбайгалийн хязгаарын Удирдах газар, Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий газрын харъяа Дорнод аймгийн Цагдаагийн газрын хооронд хил орчмын хамтын ажиллагааны асуудлаар 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр цахим хурал зохион байгуулж, Хууль сахиулах байгууллагын хүрээн дэх хил орчмын	100
-----	--	--	--	-----

			<p>хамтын ажиллагааны хөгжил, харилцан үйлчлэлийн тухай асуудлыг хэлэлцэх, ялангуяа малын хулгай, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус үйлдлийн эсрэг тэмцэх, сонирхож буй мэдээллүүдийг түргэн шуурхай харилцан солилцох асуудлыг талууд онцгой анхаарахаа илэрхийлсэн.</p> <p>Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн яам болон Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яам хооронд Хил орчмын бүс нутгийн Дотоод хэргийн албадын хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн хүрээнд хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх салбарын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, бэхжүүлэх, өргөжүүлэх зорилгоор хамтран ажиллах тухай Өвөрбайгалийн хязгаарын Засгийн газарт болон эрхэм хүндэт В.П Еговцев-аас Дорнод аймгийн Цагдаагийн газарт 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр ирүүлсэн 1/4285 дугаартай албан бичгийг хүлээн авч 2022 оны 06 дугаар сард хамтарсан хурлыг зохион байгуулахаар төлөвлөсөн.</p>	
35.	<p>Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах. /ГХУСА33-2.5.2/</p>	<p>Мэргэжлийн байгууллагаас заавар, зөвлөмж хүлээн авч хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Нийслэлийн байгаль орчны газартай хамтран нийслэлийн ногоон бүсийн 12 байгаль хамгаалагч, 30 иргэнд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан.</p>	90
36.	<p>Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд “Байгалиа хамгаалъя” олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах. /ГХУСА33-2.5.3/</p>	<p>Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн мэдлэг, ойлголт дээшилж, урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоо нэмэгдсэн байна.</p>	<p>Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг “Ногоон дуу хоолой” нэрийн доор энэ оны 04 сарын 15-ны өдрөөс 05 сарын 15-ны өдрийн хооронд орон даяар “Зөв мод-Зөв арчилгаа” уриатайгаар Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Дээрх аяны хүрээнд мод тарьж ургуулахтай холбоотой технологийн заавар, зөвлөмж бүхий шинжлэх ухаан, танин мэдэхүйн үндсэн видео шторк 10, зурагт постер 18 тус тус бэлтгэж, иргэд олон нийтэд сурталчилсныг 114.462 хүн дэмжиж, 12.509 хүн эерэг сэтгэгдэл үлдээж, 130.154 хүн бусдад түгээсэн нь давхардсан тоогоор 14.265.656 хүнд хүрч иргэдийг мод тарихад уриалсан, мод тарих, ургуулах соёлыг дэлгэрүүлсэн, хандлага мэдлэг ойлголтыг</p>	100

			нэмэгдүүлсэн, буруу дадал хандлагад эергээр нөлөөлсөн, зөв үйлдэлд уриалж сэдэлжүүлсэн арга хэмжээ болсон.	
2.6. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр				
37.	Мал аж ахуйн нэгдсэн системд малын бүртгэлийн дэд сангуудыг нэгтгэх ажлыг эрчимжүүлж, зохион байгуулах. /ГХУСА33-2.6.1/	Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд шинэчлэлт хийсэн байна.	Мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хөдөө орон нутгаас төв суурин газарт худалдан борлуулагдаж буй мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд олгогдож байгаа мал эмнэлгийн цахим гэрчилгээг Цагдаагийн байгууллагын нэгдсэн системд холбох ажлыг зохион байгуулан алба хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Уг мэдээллийг Цагдаагийн байгууллагын нэгдсэн санд холбосноор мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажил хариуцсан болон замын постуудад ажиллаж байгаа алба хаагчид, хэсгийн төлөөлөгч нар өөрийн хариуцсан нутаг дэвсгэрээс төв, суурин газарт тээвэрлэгдэн хүргэгдэж байгаа мал, маханд бүрэн хяналт тавьж ажиллах нөхцөл бололцоо бүрдсэн. Цагдаагийн байгууллагын хэмжээнд мал, мах худалдан борлуулдаг иргэдийн судалгааг нэгдсэн программд оруулж эрх бүхий алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ашиглах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл технологи, холбооны төвийн Мэдээллийн технологийн хэлтэстэй хамтарч хийсэн цагдаагийн байгууллагын Patrol2.police.gov системд Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, нэгжүүдээс мах, махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг 2038, туслах малчин 1820 мал нядалгааны газрын ажилчид болон хөлсөөр мал нядалдаг 834 иргэнийг бүртгэл судалгаанд авч тус санд бүртгэсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн хуралд 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр цахимаар оролцож “Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх санал”-ын талаар мэдээлэл хийсэн. Хурлаар 3 асуудлыг шийдвэрлүүлэхээр хэлэлцүүлсэн.	100
38.	Алдсан, олдсон малыг түр харгалзах газар /хашаа/-тай болгох асуудлыг судалж, шийдвэрлэх. /ГХУСА33-2.6.2/	Алдсан, олдсон малыг түр харгалзах газартай болсон байна.	Эрүүгийн цагдаагийн албаны нэр дээр “алдуул олдсон” малыг түр харгалзах хашааг барих, 15 жилийн хугацаатай эзэмших эрхтэй, улсын бүртгэлийн эрхийн Э-201038746 дугаар бүхий Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 999.2 м.кв газрыг эзэмших эрхийн гэрчилгээг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр гаргуулан авч, кадастрын зураг хийлгэж, алдсан, олдсон малыг түр харгалзах газар /хашаа/-тай болох асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн иргэдийн	100

			төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн ажлын албаны энэ оны хийх ажлын төлөвлөгөөнд тусгуулсан.	
2.7. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр				
39.	Согтуурах, мансуурах донтой хүний албадан болон сайн дурын эмчилгээний үр дүнг дээшлүүлэх, нийгэмшүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх. /ГХУСА33-2.7.1/	Хөтөлбөрт 150-аас доошгүй согтуурах, мансуурах донтой хүнийг хамруулсан байна.	Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 37 эрүүлжүүлэх, саатуулах байр үйл ажиллагаагаа явуулж байна. /Нийслэлд 9, 21 аймагт тус бүр 1, сум дундын цагдаагийн хэлтэст 7/ Үүнээс тусдаа байртай 19, цагдаагийн газар, хэлтсийн байранд 18 /үүнээс байрны хонгилд 10/ тус тус ашиглаж байна. Нийслэлийн Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Завхан аймаг дахь цагдаагийн газрын Тосонцэнгэл сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх саатуулах байрууд 100 хувь стандарт, шаардлага хангасан байртай байна. Дээрх Эрүүлжүүлэх, саатуулах байрны 21 буюу 56,7 хувь нь цаашид засвар хийх шаардлагатай, 4 буюу 10,8 хувь нь шинээр бариулахаар төсвийн тооцоо гаргасан, тайлант онд 10 буюу 27.0 хувьд нь урсгал засвар хийсэн. Энэ оны эхний 05 сарын байдлаар улсын хэмжээнд архины албадан эмчилгээнд 265, сайн дурын эмчилгээнд 281 хүн хамруулсан байна.	90
40.	Архисах өвчтэй хүний асуудлыг дэмжих, тусламж үйлчилгээ үзүүлэх, эмчлэх тусгайлсан асрамжийн газрыг байгуулах ажлыг эхлүүлэх. /ГХУСА33-2.7.2/	Тусламж үйлчилгээ үзүүлэх, эмчлэх тусгайлсан асрамжийн газар байгуулах санал танилцуулга хүргүүлж, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн байна.	Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны "Согтуурах, мансуурах донтой хүнийг эмчилгээнд хамруулах талаар авах арга хэмжээний тухай" А/580, А/228 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан арга хэмжээг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Ар гүнтийн аманд байрлах "Цагаан өргөө" сувилалд батлагдсан хуваарь, томилгооны дагуу энэ оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 03 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл, 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 11-ний өдрийн хооронд 21 хоногийн хугацаатайгаар 2 удаа албадан эмчилгээнд хамрагдсан 97 өвчтөнийг эмчлэгдэх хугацаанд алба хаагчид үүрэг гүйцэтгэж ажилласан. Архисах өвчтэй хүний асуудлыг дэмжих, тусламж үйлчилгээ үзүүлэх, эмчлэх зорилгоор анагаах ухааны доктор Б.Пүрэвжаргалтай "Архины хор уршиг, архинаас татгалзах сэтгэл зүй" сэдвээр уулзалт зохион байгуулж фм 95,1, Өглөөний сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэсэн. Чингэлтэй дүүргийн цагдаагийн газраас дүүргийнхээ Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтарч зорилтот бүлгийн, хорих ангиас суллагдсан болон, орон гэргүй	70

			<p>тэнэмэл амьдралтай, согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэдийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл олгох зорилготой зохион байгуулсан "ЭЗЭН ХИЧЭЭВЭЛ-ЗАЯА ХИЧЭЭНЭ" сургалт өдөрлөгийн арга хэмжээнг зохион байгуулж 21 иргэнийг оролцуулсан.</p> <p>"Зөв дадал" төрийн бус байгууллагатай хамтран архинд донтох эмгэгтэй болон давхар хамааралтай болсон иргэдийн нийгмийн идэвхийг сэргээх, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, нийгэмшүүлэх, соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн аяныг зохион байгуулж, архинд донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилготой "Хорт зуршилгүй залуу-2022" төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p>	
41.	<p>Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүлжүүлэх, баривчлах байрны орчин, үйлчилгээг боловсронгуй болгоход шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах. /ГХУСА33-2.7.3/</p>	<p>Шаардагдах төхөөрөмжөөр эмчилгээ, үйлчилгээний дээшилсэн байна.</p>	<p>тоног хангаж, сургалт, чанар</p> <p>Архангай, Хэнтий, Булган, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн газар, хэлтсүүд 2022 оны эхний улиралын байдлаар эрүүлжүүлэх, саатуулах байранд 48.000.000 төгрөгний засвар үйлчилгээг хийсэн байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлаас баталсан цагдаагийн байгууллагын 2022 оны төсөвт Архангай аймаг дахь цагдаагийн газрын барилгын /Эрүүлжүүлэх, саатуулах байртай/ 1,2 тэрбум төсөв батлагдаж, Архангай аймгийн засаг даргын тамгын газраас барилга бариулах газрын асуудлыг шийдвэрлэж, барилгын зураг төслийг "ББСМО" ХХК-аар архитекторын шийдэл судалгааг гаргуулан нийт 5.4 тэрбум төгрөгөөр Цагдаагийн газрын албан контор, түр саатуулах байрны 2 блокийг 2022 онд бариулахаар төлөвлөн тендерийг зарлуулан ажиллаж байна.</p> <p>Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу 2023 оны төсвийн хязгаарын санал, төсвийн төсөлд тусгуулахаар Булган, Говьсүмбэр, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газруудад шинээр эрүүлжүүлэх, саатуулах байр барих зураг төслийг гүйцэтгүүлэн бэлэн болгож баталгаажуулсан, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын эрүүлжүүлэх байрны засварын саналыг хүргүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.</p> <p>Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 7 дахь зорилгын 7.1.3 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/10 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.3.3.3 дахь заалтад</p>	100

			<p>“Эрүүлжүүлэх, саатуулах байруудын нөхцөлийг сайжруулах, нийслэлийн хэмжээнд нэгдсэн эрүүлжүүлэх, саатуулах байр барих бэлтгэл ажлыг хангах” зэргээр тусгагдсан байдаг.</p> <p>Энэ чиглэлээр Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, Улаанбаатар хотын баруун, зүүн бүсэд нэгдсэн эрүүлжүүлэх, саатуулах байр барих дэд бүтэц, шугам сүлжээ бүхий газрын асуудлыг судлаж, шийдүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Эрүүлжүүлэх, саатуулах байрны ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга, сургалт, нөлөөллийн ажлыг тухай орчин нөхцөлд нь явуулахтай холбогдуулан 37 эрүүлжүүлэх, саатуулах байранд 167.960.000 төгрөгийн тоног төхөөрөмж бүхий иж бүрэн компьютер, принтер, проектор, проекторын дэлгэц, гар хатаагч зэргийг худалдан авах зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэж үзэж Монгол улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд Архидан согтуурахтай тэмцэх сангийн хөрөнгөөр 2022 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрүүлжүүлэх, саатуулах байрны орчин нөхцөл, үйлчилгээг боловсронгуй болгоход шаардлагатай тоног, төхөөрөмжийн зардлын тооцоо, үнийн санал, техникийн үзүүлэлт, танилцуулгыг энэ оны Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргын 13/95 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p>	
42.	<p>Эрүүлжүүлэх, баривчлах байрны үйлчлүүлэгчдэд (баривчлагдсан этгээд) хууль эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт явуулах. /ГХУСА33-2.7.4/</p>	<p>Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, хэрэгцээтэй мэдээлэл, сургалт орсон байна.</p>	<p>Улсын хэмжээнд энэ оны эхний 5 сарын байдлаар 31966 иргэн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3455 нэгжээр буюу 12,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Улсын хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдээс ерөнхий 11, тусгай 445, соён гэгээрүүлэх 154, нийт 610 арга хэмжээг зохион байгуулж, сургалт 2977, уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага 207, өдөрлөг 84 удаа зохион байгуулж, 5938 аж ахуйн нэгж, байгууллагын 95419 иргэдийг хамруулсан байна.</p> <p>Архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагад 9756 мэдэгдэл, 1009 шаардлага өгч биелэлтийг шалгаж гэмт хэрэг, зөрчлөөс</p>	100

			<p>урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй 239 иргэн, 93 хуулийн этгээдэд 242, 650,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.</p> <p>Мөн Орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийг шинэ Коронавирусийн /ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нийслэл хотод орон гэргүй тэнэмэл байдлаар амьдардаг иргэдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах, нийгэмшүүлэх “Тэнэмэл” тусгай арга хэмжээг энэ оны 02, 03 дугаар сард 2 удаа зохион байгуулж, нийт 209 хүнийг олж тогтоон, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулснаас 13 иргэнийг ар гэрт нь, коронавируст халдвар /ковид-19/-ын эерэг хариу гарсан 1 иргэнийг “Энэрэл” эмнэлэгт, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Нийгмийн хамгааллын тусгай төв”, “Өлзийт асар”, “Титэм констракшин”, “Дөлгөөн минж”, “Шинэ амьдрал ялагч” зэрэг 5 төрийн болон төрийн бус байгууллагуудад 195 иргэнийг тус тус хүлээлгэн өгч ажилласан.</p> <p>Төмөр зам дахь цагдаагийн газраас албадан эрүүлжүүлэх байранд эрүүлжүүлэгдсэн нийт 1063 эмэгтэйд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэрхэн хаана хандах, мөн хүүхдийн эсрэг хүчирхийллийн чиглэлээр яриа таниулга хийж, тусламжийн хуудас 620 ширхэгийг тарааж ажилласан. Аймаг нийслэлийн насан туршийн боловсролын төвтэй хамтран 60 хүүхдэд суурь боловсрол олгох сургалт явуулсан байна.</p>	
43.	<p>Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах.</p>	<p>Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийг тодорхой хувиар бууруулна.</p>	<p>Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, архины зохисгүй хэрэглээг багасгах, тэднийг зөв үйлдэлд уриалах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Зөвийг зөвлөө” арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 03-наас 24-ний өдрийн хооронд улсын хэмжээнд зохион байгуулж 9 их, дээд сургууль, 26 телевиз, радио, сайт, сонин зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, 3 спортын холбоо, 6 төрийн байгууллага, нийт 46 төрийн болон төрийн бус байгууллагын 74600 ажилтан, алба хаагч, 66 олны танил эрхмийг аянд нэгдүүлж, гудамж талбай, аж ахуйн нэгж, байгууллагын гадна талд байрлах 780 лед дэлгэц, 485 томоохон самбарт хулдаасан хэвлэлийг байршуулж, архины хор уршгийг олон нийтэд сурталчилсан.</p> <p>Дээрх ажлын хүрээнд 21 аймаг, 9 дүүрэг, 8106 алба хаагч, 14585 иргэний цахим хуудасны ковер зургийг солиулж, давхардсан</p>	100

			<p>тоогоор 1277 видео шторк, 2748 постер, нийт 4025 контентийг бэлтгэн Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, дүүрэг, орон нутгийн цахим хуудсанд байршуулсан нь 6,928,119 хүнд хүрч, 643,890 хүнд таалагдаж, 2,566,609 удаа бусадтай хуваалцсан байна.</p> <p>Түүнчлэн давхардсан тоогоор их, дээд болон ерөнхий боловсролын 1712 сургууль, зорилтод бүлгийн иргэд болон эрүүлжүүлэх саатуулах байранд хүргэгдсэн нийт 4331 иргэн, төрийн 596, төрийн бус 1223 байгууллагатай хамтран 543 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион явуулж 9229 төрлийн зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг 44844 ширхгийг бэлтгэн тарааж, “МҮОНРТ”, “TV5”, “TV-9”, “UBS”, “MNS”, “EAGLE”, “MN25”, “NTV” зэрэг төв, орон нутгийн 26 телевизийн зочны цагаар давхардсан тоогоор 105 удаа, 17 FM радио, 28 сонин, 36 цахим сайт /пейж/-д давхардсан тоогоор 1609 мэдээ, мэдээллийг байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн.</p>	
2.8. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр				
44.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх, цахим технологи ашиглах хөгжүүлэлтийг нэмэгдүүлэх. /ГХУСА33-2.8.2/	Судалгаа хийж, санал, зөвлөмж хүргүүлсэн байх.	<p>Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын мэдээллийн аюулгүй байдал, технологийн үйл ажиллагаанд шаардлагатай программ хангамж, техник тоног төхөөрөмжийн судалгаа, 2021 оны 11 дүгээр сард ЦЕГ-ын төсвийн хөрнөгөөс 821 сая төгрөгийн зардлыг шийдвэрлүүлж, тендерт зарласан “Вертексмон” “Тодика”, Ай-ти-Зон ХХК-иас 762,1 сая төгрөгний үнэ бүхий Checkpoint 6000 техник, тоног төхөөрөмж /багц1/, Firewall лиценз /багц3/, 57,1 сая төгрөгний үнэ бүхий техник хэрэгсэлийг тус тус бэлтгэн нийлүүлсэнийг хүлээн авч, тоног төхөөрөмж, программ хангамжийг суурилуулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.</p> <p>Цагдаагийн Ерөнхий газрын даргын энэ оны А/28 дугаар тушаалаар байгуулагдсан “Цагдаагийн байгууллагын жолоодох эрхийн үйл ажиллагааг мэдээллийн технологийн давуу талыг ашиглаж боловсронгуй болгох, ашиглагдаж байгаа программ хангамж, мэдээллийн санг шинээр боловсруулах, шинэчлэх, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх” үүрэг бүхий ажлын хэсгээс Бүртгэл хяналтын төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа Авто сургуулийн бүртгэл, жолоочийн шалгалт авах программ хангамжид нэмэлт хөгжүүлэлт хийж, туршилтын журмаар</p>	70

			<p>ашиглаж байгаа ба жолоочийн мэдээллийн санд нэмэлт хөгжүүлэлтийг хийж байна.</p> <p>Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан болон Америкийн Нэгдсэн Улсын сураггүй алга болсон болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд туслах Олон Улсын төв (ICMEC) байгууллагын үйл ажиллагаанд ашигладаг CyberTip систем рүү шууд хандах эрхийг авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Фэйсбүүк олон нийтийн сүлжээ ашиглан Монгол улсын иргэдийг залилсан гэмт хэргийн талаарх мэдээлэл, судалгааг МБА-ны Залилах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс гаргуулан, хохирлын хэмжээ өндөр хэргүүдийг түүвэрлэн англи хэл рүү орчуулж энэ оны 03 дугаар сарын 22-ны өдөр Мета компанид хүргүүлсэн.</p> <p>Залилах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд фэйсбүүк компанитай хамтран ажиллах ажлын хэсэгт 2 алба хаагч ажиллаж Фэйсбүүк компаний Ази номхон далайн бүс хариуцсан ажилтан Майклтай харилцах цахим шуудангийн орчуулгыг тогтмол хийсэн.</p>	
45.	Цахим хэрэглээний донтолт, түүний хор уршиг, цахим халдлагаас хамгаалах болон хүүхдийн насны онцлогт тохирсон цахим хэрэглээг хяналттай, хязгаартай байдлаар нэвтрүүлэх, бодлогыг боловсролын бүх шатанд хэрэгжүүлэх. /ГХУСАЗЗ-2.8.3/	Бодлогын хэрэгжилт хангагдаж, үр дүнд хүрсэн байна.	<p>Хүн амд цахим орчны зүй зохистой хэрэглээний талаар мэдлэг, мэдээлэл олгох, ёс зүйтэй хэрэглээг төлөвшүүлэх, цахим орчинд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Харилцааны холбооны зохицуулах хороотой хамтран “Цахим соёл” арга хэмжээг зохион байгуулж, хүүхэд, иргэд, олон нийтэд Монгол HD”, “TV8”, “MYOHT”, “TB6”, “C-1”, “Neguun”, “Tsahur.mn”, “Mass.mn”, “Tug.mn”, “Zarig.mn”, “Toim.mn”, “TV6 mongolia” зэрэг сайт, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл өгч, түгээж ажилласан.</p> <p>Монгол Улсын Засгийн газар болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн 2017-2022 оны улс орны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Олон Улсын сураггүй алга болсон болон мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд туслах төв /ICMEC/-тэй хамтран 2022 оны 01 дүгээр сарын 10-наас 12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Цахим орчин дахь хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зүй” сэдэвт сургалтад тус хэлтсээс “Цахим орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал” сэдвээр илтгэл мэдээлэл тавьж, тус сургалтад 15 алба хаагчийг хамруулсан.</p> <p>Түүнчлэн Фэйсбүүк олон нийтийн сүлжээнд хяналт тогтоон Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйл</p>	100

			“Биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлүүлэхийг хориглох”, мөн хуулийн 5 дугаар зүйл “Садар самууныг сурталчлахыг хориглох”, Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйл “Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих”-д заасан зөрчлийн шинжтэй үйлдэл гаргасан 50 цахим хаяг болон нийтлэлүүдийг устгуулах хүсэлтийг Фэйсбүүк компанид уламжилж өгөх талаарх албан бичгийг 2022 оны 03, 06 дугаар сард тус тус Харилцаа холбооны зохицуулах хороонд хавсралтын хамт хүргүүлсэн.	
Гурав: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийн хүрээнд:				
46.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд авто зам, замын байгууламжийн стандарт, шаардлага, технологийн горимд тавих хяналт, хариуцлага, түүний үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авах. /ГХУСА33-3.1/	Авто зам, замын байгууламжаас шалтгаалсан зам тээврийн осол үүсгэж болох эрсдэлт нөхцөл байдал буурна.	Улсын болон нийслэлийн төсөв хөрөнгөөр Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй 7 зам барилгын ажилд тус хэлтсийн алба хаагчид тогтмол хяналт тавьж гүйцэтгэгч байгуулагаас зорчих хэсгийг түр хаах болон асфальт бетон хучилт хийх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэглэл байрлуулах үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж, зөвлөмж, зааварчилгаа өгч хяналт тавин ажиллаж байна. Иргэд, байгууллагаас Нийслэлийн захирагчийн ажлын алба болон Нийслэлийн Засаг даргын энэ оны А/527 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс зохих зөвшөөрлийг авалгүйгээр зорчих хэсгийг сэтэлсэн, явган хүний зам, талбай дээр засварын ажил хийж байсан 6 зөрчлийг илрүүлж нийслэлийн мэргэжлийн хяналтын газар болон нийслэлийн замын хөгжлийн газарт арга хэмжээ тооцуулахаар шилжүүлсэн. “Улаанбаатар хотын авто замын сүлжээний гудамж замуудын тэмдгийн байдалд үзлэг, шалгалт, тооллого хийх” ажлын хүрээнд нийт 162 гудамж замд тэмдгийн үзлэг хийж Хан-Уул, Баянзүрх, Баянгол зэрэг 3 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 19 тэмдгийг тэгшлэх, Хан-Уул, Баянгол, Сонгинохайрхан зэрэг 3 дүүргийн нутаг дэвсгэрт 42 ширхэг тэмдгийг шинээр байрлуулах, 113 ширхэг тэмдгийн арчлалт хийх ажлыг Улаанбаатар зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-аар хийлгэсэн.	90
47.	Ой, ан, байгалийн ургамлын ашиглалт, хамгаалалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх. /ГХУСА33-3.2/	Улсын хэмжээнд 1-ээс доошгүй нэгдсэн шалгалт хийгдсэн байна.	Ой, ан, байгалийн ургамлын ашиглалт, хамгаалалтын байдалд Хүрээлэн буй хяналтын хэлтэстэй хамтран урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийхээр төлөвлөн ажиллаж байна. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шийдвэрлэлтийг ахиулах, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж хяналтын пост ажиллуулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийг хяналтад авах зорилгоор “Эрэлч нохой-2022” хэсэгчилсэн арга хэмжээг хот орчмын улсын тусгай	90

			<p>хамгаалалттай газруудын постуудад энэ оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 12 хоногийн хугацаатай зохион байгууллаа.</p> <p>Арга хэмжээний хүрээнд нийт 10 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулан, хуулийн хүрээнд зөрчлийн материалыг харьяаллын дагуу холбогдох нийслэл, дүүргийн мэргэжлийн хяналтын газар, хэлтсүүдэд шилжүүлэн шийдвэрлэсэн. Эргүүл, хяналт шалгалтын хүрээнд Дархан цаазат болон байгалийн цогцолбор газруудад үйлдэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй “нохой зээх нэртэй амьтныг агнасан, хууль бусаар мод бэлтгэсэн, халуун буга амьтны эвэр түүсэн, ил гал түлсэн” зэрэг үйлдлийг илрүүлэн, таслан зогсоож, “нохой зээхийн арьс 1 ширхэг, бичиг баримтгүй галт зэвсэг 1 ширхэг зэргийг хураан авч, харьяалах нутаг дэвсгэрийн байгаль орчны улсын байцаагчид хүлээлгэн өгч ажилласан. Мөн Дархан цаазат болон байгалийн цогцолбор газруудад эргүүл, хяналт шалгалтаар байгаль орчны улсын байцаагч 8, цагдаагийн байгууллагаас 16 алба хаагчид 4 эрэлч нохойны хамт тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнт эргүүлээр 12 өдөр, нийт 132 цаг үүрэг гүйцэтгэж ажиллаа.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 2001 онд ховор амьтны жагсаалтад багтсан “Халиун буга”-н эвэр түүхийг хориглосон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Хустайн байгалийн цогцолбор газарт шөнийн цагаар эргүүл хяналт явуулах ажлыг 2 өдөр зохион байгуулан, хууль бусаар байгалийн цогцолбор газарт нэвтэрч халиун бугын эвэр түүж байсан 6 зөрчлийг илрүүлэн ажилласан.</p>	
48.	<p>Гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж суллагдсан хүнд хяналт тавих тогтолцоо, зохион байгуулалтыг боловсронгуй болгох. /ГХУСА33-3.3/</p>	<p>1-ээс доошгүй оновчтой шийдлийг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд шүүхээс тэнсэн суллагдсан 277, хорих ялаас тэнсэн суллагдсан 182, Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2, жирэмсэн, 3 хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 10, хорих ял эдлээд суллагдсан 174 нийт 647 хүнд өнөөдрийн байдлаар хяналт тогтоон ажиллаж байна.</p> <p>Цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн “Захиргааны тоо бүртгэл”-ийн захиргааны хяналтад байгаа этгээд цэсэнд өөрчлөлт оруулахаар 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн</p>	70

			13-2/1170 дугаартай албан бичгээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас саналыг авч Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба руу 13/1437 дугаартай албан бичгээр санд өөрчлөлт оруулах саналыг хүргүүлсэн. Энэ оны эхний 06 сарын байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих ангиудаас суллагдсан 54 хүний материалыг бүртгэж харьяа оршин суух Цагдаагийн байгууллага руу нь хяналт тогтоолгохоор шилжүүлсэн.	
49.	Иргэдийн оролцоотой замын хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд E-Police цахим програм ашиглан замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангуулах ажлыг судалж, боловсронгуй болгох. /ГХУСА33-3.4/	Замын хөдөлгөөний дүрэм баримталдаггүй жолооч нарыг иргэд, олон нийтийн тусламжтайгаар илрүүлж, дүрэм баримтлах хандлагыг төлөвшүүлнэ.	Иргэд гар утсандаа “E-police” аппликейшн-ийг суулгаж замын зөрчил гаргасан жолооч, иргэдийн автомашиных нь 3 талаас нь зургийг авч зөрчлийн талаархи мэдээллийг илгээдэг. E-police” аппликейшныг ашиглах эрх зүйн орчны бүрдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.3-т заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтран батлах “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам”-ын төслийг боловсруулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд хүргүүлсэн. Замын хөдөлгөөний удирдлагын төв, “Go Smart” ХХК-тай хамтран “E-Police” аппликейшныг 2022 онд хөгжүүлэлт хийж зөрчлийн давхардал үүсэх, цэс хэсэгт замын хөдөлгөөний дүрэм, аппликейшныг ашиглах заавар зэргийг нэмж оруулж өөрчилсөн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог ханган бэлэн бус хэлбэрээр энэ оны эхний хагас жилийн байдлаар 43265 зөрчил илрүүлэн зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн шийтгэлийн хуудсыг тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгч этгээдийн бүртгэлтэй хаягаар хүргүүлэх, гар утсанд нь торгуулийн мэдээллийг мессеж хэлбэрээр хүргүүлэн 865.300.000 төгрөгийн арга хэмжээ тооцон ажилласан.	100
50.	Замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд иргэдээс олон нийтийн байцаагчийг ажиллуулах. /ГХУСА33-3.5/	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хандлага, мэдлэг ойлголт нэмэгдэж, зөрчлийн гаралт буурна.	Тээврийн цагдаагийн албанаас олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд санал хүргүүлснээр 2022 оны 01 дүгээр сарын 26–ний өдрийн 03 дугаар тогтоолоор замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог 32 байсныг 90 ажилтан байхаар тогтоож, олон нийтийн цагдаагийн ажилтны цалин урамшууллыг төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээний 9 дүгээр	100

			<p>зэрэглэлийн 1 дүгээр шатлалын /ТТ-9.1/ дүйцүүлэн 641.363 /зургаан зуун дөчин нэгэн мянга гурван зуун жаран гурав/ төгрөг байхаар тогтоосон. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2022 онд 70 олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулах шийдвэр гаргасны дагуу болзол шаардлага хангасан иргэдийг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд Олон нийтийн цагдаа бэлтгэх сургалтыг 2 удаа зохион байгуулж эрэгтэй -47, эмэгтэй -13 нийт 60 олон нийтийн цагдаагийн ажилтан үүрэг гүйцэтгүүлэн ажиллаж байна.</p>	
51.	Халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах.	Халаасны хулгайн гэмт хэрэг буурсан байна.	<p>Хулгайлах, Халаасны хулгайн гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж 2022 оны эхний хагас жилд “Мал мах-Хяналт”, “Сар шинэ 2022”, “Илрүүлэлт оргодол”, “Шийдвэрлэлт”, “Carback”, “Арлын дугаар”, “Ломбард хяналт”, “Халаас”, “Бүртгэл” зэрэг ерөнхий болон тусгай арга хэмжээг зохион байгуулснаар нийслэлд 2022 оны эхний 05 сарын байдлаар Хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 26,1 хувьтай ба урьд оны мөн үеийнхээс 1,0 хувиар, Халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлт 22,1 хувьтай ба 5,4 хувиар тус тус өссөн байна.</p> <p>Халаасны хулгайн гэмт хэргийн 5189 мэдээлэлд дүн шинжилгээ хийж, 26 бүлэг, 995 сэжигтэй этгээдийг тогтоон, бүлэглэлийн зураглал гаргаж, тэдгээрийн гэмт үйлдлийг баримтжуулж, хяналт тавин ажиллаж байна.</p> <p>“Халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр ерөнхий боловсролын 1949 сурагч, “Улаанбаатар эрдэм” их сургуулийн 60 оюутан, алба хаагч, нийт 2009 иргэнд сургалт орж, мэдээ мэдээлэл өгч, богино хэмжээний шторк үзүүлж, дээрх төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон илрүүлсэн хэрэг, зохион байгуулж буй арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 3 удаа мэдээллийг иргэд олон нийтэд хүргэсэн.</p> <p>Гэмт хэргийн улмаас алдагдсан гар утсыг техник технологи, программ хангамжийн дэвшлийг ашиглан хяналтад авах, гар утасны хулгайн гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэх, таслан зогсооход тулгамдаж буй асуудал сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдөр төрийн болон төрийн бус 13 байгууллагын 18 төлөөллийг оролцуулан зохион байгуулж, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргын зөвлөлийн 2 дугаар хуралдаанд “Халаасны хулгайн гэмт</p>	70

			<p>хэрэгтэй тэмцэх ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ” чиглэлээр мэдээлэл, танилцуулга хийж, мөн дээрх мэдээллийг Цагдаагийн Ерөнхий газрын даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.</p> <p>Мөн халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 56 дугаартай захирамжаар 19.000.000 /Арван есөн / сая төгрөгийн санхүүжүүлтийг шийдвэрлүүлж, төсөв батлагдсаны дагуу 4 видео шторк, 10000 хэвлэмэл материал, сургалтын материалыг “Үнэний ташуур”, “Үнэний хурц туяа” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна.</p>	
Дөрөв: Соён гэгээрүүлэх чиглэлээр				
52.	Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх чиглэлээр инфографик, шторк, контент болон цуврал нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд түгээх. /ГХУСА33-4.1/	Тайлангийн хугацаанд инфографик 100, шторк 50, контент 50, цуврал нэвтрүүлэг 40-өөс доошгүйг бэлтгэж, олон нийтэд түгээсэн байна.	Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээллийг түгээх ажлын хүрээнд “Амрыг эрье” 15, 20, минутын нэвтрүүлгийн нийт 48 удаагийн дугаар бэлтгэж МҮОНТ-ийн 1, 2 дугаар сувгаар, Эх орон, Боловсрол, Etv, Tv-5, Tv-4, Tv-9, Otv, News Chanel, Сүлд зэрэг нийт 12 телевизээр 96 удаагийн давталттайгаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажилласан.	100
53.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулах. /ГХУСА33-4.2/	Сургалтад хамруулж, үр дүнг тооцсон байна.	Цагдаагийн Ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран хэвлэл, мэдээллийн байгууллагын 54 сурвалжлагч, сэтгүүлч нарт “Эрх зүйн боловсролыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулсан.	100
54.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд тогтмол хүргэнэ.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэх, хууль эрх зүйг сурталчлах зорилгоор цагдаагийн байгууллагын албан ёсны www.police.gov.mn сайтад байгууллага, алба хаагч, аян арга хэмжээтэй холбоотой нийт 112 мэдээ, мэдээллийг бэлтгэн хянан байршуулсан байна.	100

	төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлэх. /ГХУСА33-4.4/		Эрүүгийн цагдаагийн албанаас ирүүлсэн ASAP санд эрэн сурвалжлагдаж буй хүн, эд зүйлсийн талаарх эрэн сурвалжлагдаж буй 16, эрэн хайсан 9 хүний талаарх мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвийн фэйсбүүк хуудсанд тамгалан байршуулж, бусад мэдээллийн сайтуудад мэдээллэн олон нийтэд түгээснээр 5 хүнийг олж баривчилсан байна.	
55.	Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдыг чадавхжуулах. /ГХУСА33-4.5/	Алба хаагчдыг сургалтад хамруулж, үр дүнг тооцсон байна.	Хүний эрхийн үндэсний комисстой хамтран “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалтыг зохион байгуулж Мөрдөн байцаах алба, Хар тамхитай тэмцэх газар, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, орон нутаг дахь мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий 618 алба хаагчийг, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэстэй хамтран “Хүний эрх ба алба хаагчийн эрх, үүрэг” сэдэвт 3 сарын хугацаатай бүсчилсэн сургалтыг 03 дугаар сарын 07-ны өдрөөс эхлүүлэн 37 анги, байгууллагын 7000 орчим алба хаагчийг, Сургалтын нэгдсэн төвтэй хамтран “Мөрдөгчийн харилцаа хандлага” сэдэвт сургалтыг 174 мөрдөгчдийн дунд 06 дугаар сарын 09-ны өдөр тус тус чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулсан. Америкийн нэгдсэн улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яамны Мөрдөн шалгах албаны атташе, Дэд консул Роберт Гуденкауфыг энэ оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хүлээн авч цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах чиг үүргийн хүрээнд хамтын ажиллагааг сайжруулах, цаашид хамтран хэрэгжүүлэх асуудлын талаар ярилцан хүний эрх, эрүү шүүлтийн эсрэг сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.	100
56.	ЕБС-ийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үе шаттай тэмцээн зохион байгуулах. /ГХУСА33-4.6/	Улсын хэмжээнд зохион байгуулагдаж, үр дүнг тооцсон байна.	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмүүдийн дунд явуулах уралдаан тэмцээнийг IV улиралд Нийслэлийн хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	-
57.	Төрийн алба хаагчдад төрийн, байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах. /ГХУСА33-4.7/	Сургалт зохион байгуулагдаж, үр дүнг тооцсон байна.	Цагдаагийн байгууллагын хэмжээнд “Баримт бичгийн нууц, хуурамч бичиг баримтыг таних нь”, “Баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалт”, “Төрийн болон албаны нууц”, “Төрийн болон албаны нууцын тухай хууль”, “Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал”,	100

			“Хувь хүний болон албаны нууцын тухай хуулийн үзэл баримтлал”, ЦБҮАЖ-ын “Төрийн болон албаны нууцыг хамгаалах” /код-114/, “Цагдаагийн байгууллагын албаны нууцын тухай” зэрэг 29 удаагийн сургалт зохион байгуулж, 2465 алба хаагчийг хамруулсан байна.	
58.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл үзүүлж байна “Сэргийлэгч” нэвтрүүлгийг бэлтгэн, олон нийтэд хүргэх. /ГХУСА33-4.8/	Хуваарийн дагуу нэвтрүүлэг гарч, олон нийтийн хүртээл болсон байна.	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс үзүүлж байгаа “Сэргийлэгч” нэвтрүүлэгт цагдаагийн байгууллагаас 2022 онд мэдээлэл өгөх хуваарь, сэдвийг гарган хүргүүлсэн. Цагдаагийн ерөнхий газрын “Сүлд” чуулгатай хамтран “Миний баатар, миний найз цагдаа” сэдэвт богино хэмжээний видео бичлэг хийх, оролцох жүжигчид, эцэг, эх, хүүхэд, иргэдийг сонгох, шаардлагатай эд зүйлсийг байрлуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, Дотоод хэргийн их сургууль, Шангрила зочид буудлын хажууд тус тус зураг авалт, монтаж хийлгүүлж, фэйсбүүк хуудасны “ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэс” пэйж хуудсанд байрлуулахад 11,000 хүн үзэж, 2,800 хүн бусадтай хуваалцсан байна.	70
59.	“Ногоон гэрэл-Цагаан шугам”, “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээний хөтөлбөрийг шинэчлэх, улсын хэмжээнд зохион байгуулах. /ГХУСА33-4.9/	Замын хөдөлгөөнд оролцогч хүүхдүүдийн анхаарал сэрэмж дээшилж, осол, гэмтлийн тохиолдол буурна.	Боловсролын ерөнхий газар, Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран сургуулийн өмнөх насны хүүхэд, эцэг, эхчүүдэд замын хөдөлгөөнд оролцох, зөв дадал олгох, хэвшүүлэх, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль дүрмийн мэдлэг олгох зорилгоор “Замын хөдөлгөөний цагаан толгой 2022” модуль сургалт, тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд аймаг, нийслэлээс шалгарсан 19 баг тамирчид оролцож, хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс багийн нийлбэр дүнгээр Тэргүүн байранд Баянзүрх дүүрэг, 2-р байранд Баянгол дүүрэг, 3-р байранд Сонгинохайрхан дүүрэг, Тусгай байранд Дундговь аймаг, Орхон аймгууд тус тус шалгарсан.	100
60.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, салбар зөвлөлийн гишүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэний нийгмийн байгууллагын оролцоо нэмэгдэж, урьдчилан сэргийлэх ажлын чанарт ахиц гарсан байна.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах, олон нийтийн санал, санаачилгыг дэмжих, олон нийтийн байцаагч ажиллуулах зэргээр иргэдийн оролцоог нэмэгдүүлж, олон нийтийн санал санаачилгыг дэмжиж 2022 оны эхний хагас жилийн байдлаар 5938 аж ахуйн нэгж, байгууллагын 95419 хүн, олон нийтийн	100

	<p>сайжруулах, сургалт зохион байгуулах. /ГХУСА33-4.10/</p>		<p>цагдаагаар 594 хүн, төрийн байгууллага 5564 , төрийн бус байгууллага 563, хөршийн хяналтын 2595 бүлэг, малчдын бүлэг, холбоо, нөхөрлөл-695, оюутан цагдаа 252, өсвөрийн сэргийлэгч-213, хамтарсан багийн 408 гишүүн, 270 ерөнхий боловсролын сургуулийн “School police” эргүүлийн иргэдийг татан оролцуулж мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан байна.</p> <p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр “Epolice апп”-ийг Замын хөдөлгөөний удирдлагын төв, “Go Smart” ХХК-тай хамтран хөгжүүлэлт хийж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог ханган бэлэн бус хэлбэрээр энэ оны эхний хагас жилийн байдлаар 43265 зөрчил илрүүлэн зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн шийтгэлийн хуудсыг тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгч этгээдийн бүртгэлтэй хаягаар хүргүүлэх, гар утсанд нь торгуулийн мэдээллийг мессеж хэлбэрээр хүргүүлэн 865.300.000 төгрөгийн арга хэмжээг тооцжээ.</p>	
<p>Нийт-60 ажил, арга хэмжээнээс хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй-4 ажил байна. Дундаж үнэлгээ</p>			<p>96.6</p>	

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР